

ЧИМЭЭГҮЙ, ТЭД УЙЛЖ БАЙНА

Сурвалжилга

МУИС-ийн Сэтгүүлчийн ангийн оюутан Г. Намуун

Хүйтэн ханан дээр ой мод, ус, ургамал зурж өнгийн будгаар будлаа гээд зэрлэг байгалийг орлож чадахгүй.



Урсгал ус, өтгөн ой, зах нь үл харагдах хязгааргүй талдаа эрх дураараа амьдрах хувь дутав. Амьтад эрх чөлөө, зэрлэг байгалиа мартан амьтны хүрээлэнгийн төмөр тор, шилэн хоргонд хоригдол болон бүх амьдралаа өнгөрүүлсээр. Манай улсдаа ганц гэдэг “Улаанбаатар” амьтны хүрээлэнгийн 60 гаруй төрлийн 200 гаруй амьтан 100 хүрэхгүй метр квадрат талбайд хоригдож байна. Үүнийг амьтны хүрээлэн гэж хэлэхэд хэцүү.

“Улаанбаатар” амьтны хүрээлэнгийн хаалгаар ормогц чийглэг, бүгчим агаар угтлаа. Хаалганы өөдөөс харсан урт шилэн лангуунаас

“Сайн байна уу? Та тасалбар худалдаж авснаар манай хүрээлэнгийн амьтдыг үзэх боломжтой” хэмээн угтлаа. Хүүхэд таван мянга, том хүн арван мянган төгрөг аж. Эхний зааланд Австралийн долгионт тоть, Африкийн циклид загас, халуун орны сармагчин, Америк илбэнх зэрэг амьтад байв. Шилэн хоргон дахь эр, эм хоёр сармагчин амьтны хүрээлэнд ирээд таван жил болжээ. Үс нь өрвийчихсөн, дүүжлүүр болгон өлгөсөн олсоор дамжин үртэс дэвссэн шалан дээр нааш цааш холхих нь өрөвдөлтэй. Угтаа бол энэ амьтан халуун орны ой, ойт хээрийн бүсэд хамгийн багадаа 20, ихдээ 150-иулаа сүрэглэн амьдрах ёстой шүү дээ.



Олон улсад амьтны хүрээлэнгийн стандарт гэж бий. Халуун орны сармагчингууд өдрийн 12 цаг гэрэлтэй орчинд байхыг шаарддаг бөгөөд үүнийг байгалийн гэрлээр зохицуулах нь хамгийн сайн гэж үздэг. Мөн агаарын урсгал хангалттай байх шаардлагатай. Тэдний амьдрах орчны талбай хамгийн багадаа 1*2.5*2.5 метрийн хэмжээтэй байх ёстой. Гэвч тэд хүн гэгч бас нэгэн амьтны сайнаар хэлбэл танин мэдэхүйн, муугаар хэлбэл мөнгө олох хэрэгсэл болж байна. Торноос гарахын хүслэн болсон сармагчингууд амьтны хүрээлэнгийн ажилчид хоол, ус өгөхдөө онгойлгодог жижиг торон хаалганы цоожийг нааш цааш савчуулан

ориполдох нь зүрх зүсмээр. Хэлж л чадахгүй байгаагаас биш төмөр торноос гарах нь тэдний туйлын хүсэл гэдэг нь илт.



Африкийн зурам, сармагчин, орог зусаг, шиншила, зараа, элбэнх, тогос сүүлт тагтаа, бөднө шувуу, туулай, цацагт хяруулууд хөрсөн дээр биш модны үртэс дээр амьдарч байна. Үртсэн хөрсөнд нь модтой чихрийн иш, чихрийн цаас, амьтдын ялгадас хаа саагүй харагдана. Тэдний үүрэнд хоёр сав байх агаад нэг нь хоол, нөгөө нь усных аж. Идэшний сав нь хүрэнтэж зузаан гэгч нь өнгөр тогтжээ. Бидний “тимон” гэж хүүхэлдэйн киноны дүрээр нэрлэдэг африк зурам халуун пааран дээр толгой гудайн хэвтэх нь африкийн саваннагийн хээр, задгай цөл, хатуу хөрстэй модгүй газарт сүрэглэн амьдардаг түүнд чийгтэй, бүгчим агаар, дөрвөлжин хана уйтай байх нь аргагүй. Хоолойндoo төмөр хүзүүвчтэй энэ бяцхан амьтад шилэн хоргоны хаалгыг ээлжлэн байн байн тогшино. Хоргоноос гарахыг хүссэн болов уу гэлтэй. Түүний хүзүүвчний талаар тодруулбал, “бид өөрсдөө энэ амьтныг сургаж гаршуулсан. Түүнийг

зочдод бариулж, үзүүлдэг” гэв. Амьтныг сургаж ноолох нь амьтантай харьцах соёл бус тамлал гэж олон улсад үздэг бус уу.



Амьдрах хувь тохиож хорвоод мэндэлнэ, халин одно. Энэ бол ертөнцийн жам. Жамаараа хорвоог орхисон амьтад бий авч хүмүүс бидний хайхрамжгүй, буруутай үйлдлээс болж амиа алдсан нь цөөнгүй. Аалз, усан гахай, туулай нь хөгшрөөд үхсэн. Харин өвчин, усны бохирдлоос болж олон загас үхжээ. Энэ нь амьтны өвдөх, гэмтэх, өвчин зэргээс ангид байх эрхийг зөрчиж байгаа хэрэг. Хар хүрэн, цагаан шаргал судалтай далайн яст мэлхий аквариумын баруун буланд огтхон ч хөдөлгөөнгүй хэвтэж харагдана. Сааралтаж бараантсан ус нь хогоор дүүрч, бохирын тунадас шилэнд нь наалдсан байв. Аквариумыг нь цэвэрлээгүй нэлээд удсан бололтой. Харин хүрээлэнгийн ажилчин “долоо хоногт нэг удаа усны амьтдын аквариум болон бусад амьтдын торыг цэвэрлэдэг” гэв. Амьтдын орчныг цэвэр байдлыг хангах стандартад тухайн амьтны ялгадас, хоолны үлдэгдэл, хоолны сав, тоглоом, байнга сууж буй тавиурыг өдөр бүр цэвэрлэж халдваргүйжүүлэх ёстой гэж заасан ч энд нөхцөл байдал өөр аж.

Урсгал усанд сүргээрээ амьдрах учиртай кайман матар тогтоол усанд ганцаараа байна. Матрын амьдарч буй хашаа нь хамгийн багадаа амьтны уртаас гурав дахин урт, усны гүн нь амьтны өргөнөөс 0.3 дахин

гүн байх ёстой. Гэтэл уг хүрээлэнгийн матрын хашааны хэмжээ амьтны уртаас хоёр дахин урт, усны гүн нь амьтны өргөнөөс 10 орчим сантиметрт гүн байв. Үүгээр зогсохгүй гүрвэлийг хамгийн багадаа 0.9x0.9 метрийн хэмжээтэй, 0.4 метрийн өндөртэй талбайд амьдарна хэмээн олон улсын амьтны хүрээлэнгийн стандартаар тогтоосон. Гэвч “улаанбаатар” хүрээлэнгийн гүрвэлүүдийн амьдрах талбайн хэмжээ 0.5x0.4 метр, 0.7x0.8 гэх мэт байгаа нь уг стандартыг хангахгүй байна.



Биологийн ангийн оюутан н.чанцалдулам “амьтны хүрээлэнд орж ирээд цочирдсон. Амьтад үнэхээр өрөвдөлтэй харагдаж байна. Энд шинээр мэндэлсэн илбэнхийн бяцхан зулзагыг жижиг төмөр торонд байгааг харахад ч хэцүү юм. Амьтдыг ийм хэцүү орчинд байлгаж, амьтдаар мөнгө олж байгаа хүмүүс юу боддог юм бэ? Амьтны хүрээлэн гэдэг чинь байгаль хамгаалах зорилгоор үйл ажиллагаагаа явуулах ёстой болохоос амьтнаар ашиг олох ёсгүй” гэв.

Биднийг сурвалжлага хийх үеэр нийслэлийн 155-р сургуулийн тавдугаар ангийн 80 гаруй сурагч уг хүрээлэнгээр зочилж байв. Сурагч б.билгүүн: “том заалны илбэнхүүд надад таалагдаж байна. Илбэнх бамбагар үслэг муур шиг санагдлаа. Шилэн дотор хийгээд гэртээ тэжээж болох юм байна” хэмээв. Иймэрхүү орчинд амьтдыг байлгаж болох юм байна гэсэн буруу сэдлийг хүүхдүүдэд өгч болохгүй л санагдах юм.

Хүүхдүүд амьтдын тор, хоргыг тогшиж дэггүйтнэ. Олон хүний хөл хөдөлгөөн, чимээ шуугиан дунд аварга могой амаа ангайж шилэн хоргоо толгойгоороо мөргөж байлаа. Энэ нь уг амьтны стрессийн шинж аж. Түүнчлэн хөвсгөр цагаан үстэй молтогчин туулай харанхуй өрөөний буланд шигдэж, соотон хоёр чихээ буулган нүд нь бүлтгэнэнэ. Ойт хээр, тал хээр, намаг балчигтай газар сүрэглэн амьдардаг түүнийг өрөөний мухарт ганцааранг нь харах хэцүү юм билээ.

Стресст орсон амьтад үүгээр дуусахгүй.

МУБИС-ийн биологийн тэнхимийн багш, доктор п.эрдэнэтүшиг “амьтад хүрээлэн буй орчинд дасан зохицохын тулд хэт их зохицуулалт хийх үед стресстдэг. Амьтдын стресс биеийн ядаргаа, өлсгөлөн, температур, орчны таагүй байдлаас үүснэ. Архаг стресс, айдаст автсанаар амьтдын дархлаа суларч өвчлөх магадлал нэмэгддэг. Зоопарк, цирк, фермийн амьтад стресст өртөх магадлал өндөр. Манай улсын хувьд амьтны хүрээлэн гэхээс илүүтэй амьтны эрхийг зөрчдөг хувийн байгууллага л бий” гэсэн юм. Хэдий дөрвөн хананы дунд дасал болтлоо амьдарсан ч тэд амьдрах орчны таагүй байдлаас болж стресстэж, сэтгэлзүйн таагүй нөхцөлд ордог байна.

Амьтны сайн сайхан байдлыг хангах дэлхийн тунхаглалд “амьтдыг таагүй байдлаас ангид байлгах эрх чөлөө” хэмээн тусгасан байдаг. Энэ нь зохих орчныг нь бүрдүүлэхийг хэлж байгаа юм. Мөн “айдас стрессээс ангид байлгах эрх чөлөөг дурдсан байдаг. Гэтэл “улаанбаатар” амьтны хүрээлэн зохиомол орчинд бүрдүүлсэн ч амьтдын амьдрах орчны наад захын стандартыг хангаж чадахгүй байна. Амьтад өөрсдийн гэсэн орон зайгүй, хязгаарлагдмал орчинд хүнээс бүрэн хамааралтай амьдрах нь

өрөвдмөөр. Унаган байгалийн ус, ой, хөрс, ургамал, агаар, байгалийн үзэгдэл зэрэг төрөлх орчныхоо шинжийг мэдэхгүй, угаас энэ тор миний амьдрах орчин хэмээн төсөөлж буй нь гачлантай. Хүйтэн ханан дээр ой мод, ус, ургамал зурж өнгийн будгаар будлаа гээд зэрлэг байгалийг орлож чадахгүй шүү дээ.

Дэлхий нийтийн чиг хандлага байгаль түүний баялгийг хамгаалах, онгон дагшин хэвээр үлдээхийн төлөө тэмцэж байхад амьтдыг хамгаалах биш байгалиас нь салгаж, үржил селекцид оруулж төрөл зүйлийг нь өөрчилнө гэдэг байж боломгүй зүйл. Онгон дагшин байгаль, зэрлэг ан амьтдаараа бахархаж омогшин ярьдаг монголчууд бид үүний хажуугаар дуугүй өнгөрөх гэж үү.

Бүхий л насаа шорон мэт бөглүү газар өнгөрөөж буй хөөрхийлөлтэй амьтдыг бид гагцхүү зугаа цэнгэл ашиг тусын төлөө золиосолсоор байх уу. Амьтад бидний гоо сайхны мэдрэмж, зугаа цэнгэл, танин мэдэхүйн золиос биш. Хайрлан хамгаалах учиртай бидний хүйн холбоо. Энэ дэлхий дээр хүн гэгч амьтан ганцаараа амьдардаггүй, тэднийг өөрийн дураар боолчлох эзэн нь биш. Хэрэв тэд хүний хэлээр ярьдагсан бол тэдний амьдрал хэчнээн хатуу, уй гунигтайг нэгд нэгэнгүй өгүүлэх байсан даа. Даан ч тэд хүний хажууд хүчин мөхөс учраас дотроо чимээгүй уйлж байгааг бид анзаардаггүй биз ээ.